



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Нягтлан бодогч
Нярав

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Статистик, мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

2. Байгууллагын эд, хөрөнгийн үзлэг, тооллогын ажлын бэлтгэлийг сайтар хангаж, үнэн зөв, чанартай зохион байгуулж 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГ

О.АНХБАЯР

